



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒1 оны 0᠑ сарын 31 өдөр

Дугаар #1᠙9.

Мандалговь

“Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхитэй
хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг
зохион байгуулах, зардал
гаргах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.2 8.2.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 335 дугаар тогтоол, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.1.7 дахь заалт, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны 1/283 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг 2021 оны 06 дугаар сарын 02-30-ны өдрийг дуустал хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулж мэргэжил арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр үүрэг гүйцэтгэгч (А.Отгонбаатар)-т даалгасугай.

2. “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, нэгдсэн удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Дасгал хөдөлгөөн хийцгээ” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг зохион байгуулахад шаардагдах 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат) Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Анхбаярт) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210545